

**Х**үмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэх, нутгийн өөрөө удирдах ёсыг төлөвшүүлэх, эрх зүйн үндсийг Монгол улсын Үндсэн хуулиар тогтоосон билээ.

Нутгийн өөрөө удирдах байгууллагын 5 дахь удаагийн сонгуулийн үр дүнд 2008 онд байгуулагдсан Монгол улсын Нийслэл Улаанбаатар хотын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь нийслэлийн иргэдийн эрх ашиг, хүсэл сонирхлыг илэрхийлж, нийслэлийн эдийн засаг нийгмийн хөгжлийн зорилтыг тодорхойлон, түүнийг хэрэгжүүлэхэд Засаг дарга, түүний багийнхан, дүүрэг, хороодтой нягт хамтран ажиллаж байна.

Нийслэлийн хөгжилд иргэд, хамт олны бүтээлч санаачлага, идэвхтэй оролцоог эрхэмлэн дэмжиж, сонгогчдынхоо итгэл найдварыг дээдлэн хүндэтгэж, нутгийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагааг бэхжүүлэх, өргөжүүлэн хөгжүүлэхийг бид зорьж байна.

Нийслэл хотынхоо хөгжил цэцэглэлтэд үнэтэй хувь нэмэр оруулж ирсэн ахмад, дунд үеийнхэн, хурал, захиргааны байгууллагын үе үеийн удирдах ажилтнууд болон бүх хүмүүст чин сэтгэлийн хүндэтгэл өргөө.


Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Тэргүүлэгчид бид сонгуулийн бүрэн эрхийн хугацаанд хэрэгжүүлэх үйл ажиллагааны үндсэн чиглэл, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн мөрийн хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэхийн төлөө бүтээлчээр хамтран ажиллахыг бүх байгууллага, аж ахуйн нэгж, иргэддээ хандан уриалж байна.

Нийслэл хот маань өдрөөс өдөрт өргөжин хөгжиж, иргэд маань аз жаргал, амжилт бүтээлээр дүүрэн байхын өлзийтэй ерөөлийг өргөн дэвшүүлье.



Нийслэлийн Иргэдийн  
Төлөөлөгчдийн Хурлын дарга

Т.Билэгт



# Нийслэлийн сүлд, далбаа

Нийслэлийн Эрх зүйн байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 1–д “Нийслэл нь өөрийн туг, сүлд тэмдэгтэй байна. Мөн зүйлийн 2–д “Нийслэлийн туг, сүлд тэмдгийн загвар, хэрэглэх журмыг Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас тогтооно.” гэж заасан.

Уг заалтыг үндэслэн Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал 1995 онд Нийслэлийн сүлд, далбааны загвар, хэрэглэх журмыг баталжээ.




Нийслэлийн сүлд тэмдэг нь мөрөвчит дугуй дүрсний төвд байрласан Богдхан уулын уламжлалт шүтээн Хангарьд байна. Хангарьд нь бат түвшин эрэмгий байдлыг илэрхийлж нийслэл хот өргөжиж, алдар нэр нь тив дэлхийд мандан бадрахын утга санааг агуулна. Нийслэлийн сүлд тэмдэг Хангарьд нь магнайдаа төрт ёс, эрдэм мэдлэгийн бэлгэдэл соёмботой. баруун гартаа түмэн олондоо үүд хаалгаа цэлгэр сайхнаар нээж өөдлөн дэвжихийн санааг илэрхийлсэн очир бариулт түлхүүртэй, зүүн гартаа энэлэн үгүй ариун тэгш оршихуйн баталгаа бадам цэцгийг нандигнан барьж, аливаа хорын үндсийг эгнэгт устган дарах санааг гишгэн зогсож буй могойгоор илэрхийлсэн байна.



Нийслэлийн туг нь мөнх хөх тэнгэрийн өнгөтэй байна. Хөх дэвсгэр дээр нийслэлийн сүлд тэмдэгийг цагаан торгоор дүрслэн алтлаг мөнгөн утсаар зээглэн урлана. Нийслэлийн туг нь нийслэлчүүд ариун цагаан сэтгэлээр төрт ёсоо дээдлэн, мандан бадрахын утга санааг бүхэлдээ агуулна. Тугийн өргөн, урт нь 1:1,5–ын харьцаатай байна.

# Улаанбаатар хотын ТОВЧ ТАНИЛЦУУЛГА



Улаанбаатарын үүсэл өргөө нь 1639–1778 онд 28 удаа нүүдэл, суудал хийж Өргөө, Номын хүрээ, Их хүрээ, Нийслэл хүрээ хэмээн нэрлэгдэж байсныг эрдэмтэд судлан тогтоож, 1639–1778 оны түүхийг нүүдлийн соёл иргэншлийн буюу Монгол орны шашин, төр, олон улсын худалдаа харилцааны төв болж хөгжсөн үе, 1778 оноос хойшхийг суурин соёл иргэншлийн шилжилтийн үе гэж үечлэн үзсэн байдаг.

Хутагтын өргөө 1651 оноос Номын хүрээ, 1706 оноос Монголын хүрээ хийдүүдийн төв болж “Их хүрээ” хэмээн нэрлэгдэх болжээ.


1911 оны 12 дугаар сарын 31-нд Монгол улс тусгаар тогтнолоо сэргээн тунхаглаж, Манж чин улсаас салан тусгаарласны дараа 1912 оны 2 дугаар сарын 9-нд Монголын улс төр, эдийн засаг, шашны төв Их хүрээг хаант Монгол улсын “Нийслэл хүрээ” хэмээн зарлан тунхагласан түүхтэй.

1924 онд хуралдсан Улсын анхдугаар хурлаас Нийслэл хүрээг улсын нийслэл болгон “Улаанбаатар” хэмээн нэрлэж, хотын хөдөлмөрчдийн хурал, засаг захиргааны дүрмийг батлан, хотын амьдралыг зохицуулан хөгжүүлэх үүргийг хариуцуулсан байна.

Одоо Улаанбаатар хот нь 1.2 сая хүн амтай, засаг захиргааны хувьд 9 дүүрэг, 152 хороотой ажиллаж байна.




# Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүтэц, зохион байгуулалт




# Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчдийн үзүүлэлт

Намын харъяалал




■ Монгол Ардын Хувьсгалт Нам 80%  
■ Ардчилсан Нам 20%

Мэргэжил




■ Эдийн засагч 31%  
■ Эрх зүйч 16%  
■ Улс төр судлаач 4%  
■ Инженер 22%  
■ Бусад 16%  
■ Багш 11%

Насны байдал




■ 28-30 нас 7%  
■ 31-40 нас 40%  
■ 41-50 нас 46%  
■ 51-ээс дээш нас 7%

Хүйсийн эзлэх хувь



■ Эрэгтэй 77.8%  
■ Эмэгтэй 22.2%

Сонгогдсон байдал



■ Анх удаа сонгогдсон 62%  
■ 2 ба түүнээс дээш сонгогдсон 38%

